

ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2020 оны 10 сарын 13 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫГ ЗАРЛАН ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ

Монгол улсын Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 61 дүгээр зүйлийн 61.1.5 дах хэсэг, 64 дүгээр зүйлийн 64.2, 67 дугаар зүйлийн 67.1 дэх хэсэг, Санхүүгийн Зохицуулах хорооны 2018 оны 377 тоот тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”, Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2020 оны 11 дүгээр сарын 25-ний өдрийн 09:00 цагт компанийн ажлын байранд хуралдуулсугай.
2. ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар дор дурдсан асуудлыг хэлэлцэхээр тогтоосугай. Үүнд:
 1. Компанийн хувьцаа нэмж гаргах, тоог тогтоох
 2. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах
3. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2020 оны 11 дугаар сарын 02-ний өдрөөр тогтоосугай.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулахтай холбогдуулан “Хурлын дэг”-ийг Хавсралт №1-ээр, “Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл”-ийг Хавсралт №2-оор, хувьцаа эзэмшигчдээс авах “Саналын хуудас”-ыг Хавсралт №3-аар, “Хурлын зар”-ыг Хавсралт №4-өөр тус тус баталсугай.
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлан хуралдахтай холбогдуулан доорх бичиг баримттай 2020 оны 11 дүгээр сарын 23-ны өдрөөс ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ийн байранд ирж танилцах эрхтэй болохыг дурдсугай.

Үүнд:

- Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах тогтоолын төсөл
 - Холбогдох материалууд
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын мэдэгдлийг хавсралт материалын хамт 2020 оны 10 дугаар сарын 15-ний дотор Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын Хөрөнгийн биржид хүргүүлэх, Хавсралт №4-ийн дагуу хурлын зарыг 2020 оны 10 дугаар сарын 18-ний дотор өдөр тутмын 2-оос доошгүй сонин, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг телевиз, Монголын Хөрөнгийн биржийн цахим хуудсаар тус тус дамжуулан нийтэд мэдээллэх, брокер дилерийн компанид хүргүүлэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бадамцэцэгт даалгасугай.

7. Саналын хуудас хүлээн авах сүүлчийн өдрийг 2020 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 17:00 цагаар тогтоосугай.
8. Компанийн ээлжит бус хурлыг удирдан зохион байгуулах комиссын даргаар ТУЗ-ийн дарга Ч.Чинзориг, комиссын гишүүнээр Б.Золжаргал, хурлын нарийн бичгийн даргаар Б.Бадамцэцэг нарыг тус тус томилсугай.
9. Хурлын тооллогын комиссын даргаар Л.Идэрзаяа, тооллогын комиссын гишүүнээр Г.Азбилэг, Ц.Энхжаргал нарыг тус тус томилсугай.
10. Хурлын бэлтгэлийг хууль, журмын дагуу сайтар зохион байгуулахыг хурал зохион байгуулахыг комисст үүрэг болгосугай.



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Ч.ЧИНЗОРИГ